



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.22 № 03/4164

танай _____ -ны № _____ -т

Тендер шалгаруулалтыг
түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240101096 дугаартай “Хөшгийн хөндий дэх аангартын барилгын ажил /Оффис цехийн Б хэсэг/” гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Энхтөгс тэмүүлэл” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

- Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
- Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
- Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
- Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
- Тендерийн нээлтийн тэмдэглэл;
- Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
- Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
- Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
- Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
- Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766007267



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.05.30 № 03/4507
танай -ны № -т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240101096 дугаартай “Хөшгийн хөндий дэх ангарын барилгын ажил /Оффис цехийн Б хэсэг/-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Энхтөгс тэмүүлэл” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“Энхтөгс тэмүүлэл” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Темплланд” ХХК-ийн тендерт санал болгож буй 3550УБ улсын дугаартай авто ачигч, 8375 УЕВ улсын дугаартай тээврийн хэрэгсэл, 2273УЕХ улсын дугаартай автомашин нь хэвийн ашиглалт, торгуулийн өр төлбөртэй, техникийн үзлэг хяналтын хугацаа дуусгавар болсон нь шаардлага хангаагүй, ТШЗ 19.2-ын 1-д заасан инженер техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлээгүй, туншлэгч “Гексаэдрклауд” ХХК-тай цахилгааны ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч тус албан тушаалд санал болгосон ажилтны мэдээллийг ирүүлээгүй, туншлэгч “Гексаэдр клауд” ХХК-ийн шүүхийн төрөлжсөн архивын лавлагааг ирүүлээгүй, зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт ирүүлээгүй, ижил төстэй ажлын мэдээллийг ирүүлсэн ч комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн хуудсыг хавсралтаар ирүүлээгүй байхад шаардлагад нийцсэн гэж хянасан захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Темплланд” ХХК болон “Гексаэдрклауд” ХХК-ийн туншлэлээс ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”. Үүнд: Угсралтын агрегат-1, Автокран /5тн/-1, Үйлчилгээний автомашин - 1, Түр байрлах сууцтай байна. Зөөврийн био 00-той байна.” гэж, ТШЗ 19.2-ын 2-т “Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт); Оролцогч өөрийн эзэмшлийн болон түрээсийн гэрээний дагуу ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим

системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.” гэж тус тус заасан байна.

1.1. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс шалгахад “Темплланд” ХХК тендерт 3550УБ улсын дугаартай авто ачигч, 2273ҮЕХ улсын дугаартай авто кран, 8375ҮЕВ улсын дугаартай тээврийн хэрэгслийг тус тус санал болгосон байна.

1.2. Тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоонд хамруулах, түүнд хяналт тавих эрхий бүхий этгээд нь Автотээврийн тухай хууль, холбогдох журамд зааснаар “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ, тээврийн хэрэгслийн торгууль төлөх, төлүүлэхтэй холбоотой асуудлыг Зөрчлийн тухай хуульд заасан эрх бүхий этгээд хариуцах тул “Темплланд” ХХК-ийн тендерт санал болгосон тээврийн хэрэгслүүд үзлэг, оношилгоонд хамрагдаагүй, торгууль, өр төлбөртэй асуудлыг энэ гомдолын хүрээнд хянан үзэхгүй.

1.3. “Авто тээврийн үндэсний төвийн” ТӨҮГ-ын авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан [/www.autobox.mn](http://www.autobox.mn)-ээс хайлт хийхэд 2273ҮЕХ улсын дугаартай тээврийн хэрэгслийн зориулалт: “Ердийн тэвштэй автомашин” гэж бүртгэгдсэн хэдий ч тендерт хавсаргасан улсын дугаарыг харуулсан фото зургаас үзэхэд кран бүхий тээврийн хэрэгсэл байх тул энэ тухай гомдол үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичигт шүүхийн төрөлжсөн архивын лавлагааг ирүүлнэ гэж заагаагүй байх тул тус лавлагааг ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

3. “Темплланд” ХХК тендерт “Гексаэдрклауд” ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан 24/26 дугаартай “Хөшгийн хөндий дэх ангарын /“Оффис цехийн Б хэсэг”/ БУА-ын барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн ажил гүйцэтгэх” туслан гүйцэтгэгчийн гэрээ /гэрээний үнэ: 60.0 сая төгрөг/ ирүүлсэн байна.

Хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, мөн тендер шалгаруулалтын баримт бичгийн зааварчилгааны 17.5-д зааснаар туслан гүйцэтгэгч нь чадавхын болон туршлагын шаардлагаас өөрт холбогдох хэсгийг хангах бөгөөд тус шаардлагыг хангасан болохыг нотлох баримт ирүүлэх ба тендер шалгаруулалтын баримт бичигт бусад шаардлагатай холбоотой нотлох баримт, мэдээлэл ирүүлэх үүрэггүй тул “Темплланд” ХХК тендерт туслан гүйцэтгэгч “Гексаэдрклауд” ХХК-ийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ерөнхий инженер-1, барилгын инженер-1, халаалт агаар сэлгэлтийн инженер-1, ус хангамж ариутгах татуургын инженер-1, холбоо дохиоллын инженер-1, цахилгааны инженер-1, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан-1, талбайн даамал-1, нийт 8 ажилтантай байх” гэж, ТШЗ 19.2-т “Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх; Дээрх инженер техникийн

ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж, дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.” гэж тус тус заасан байна.

“Темплланд” ХХК-ийн тендерт ирүүлсэн хүний нөөцийн мэдээлэл (маягт 2)-ийг үзэхэд холбоо дохиоллын инженер Б.Мягмарсүрэн, халаалт агаар сэлгэлтийн инженер А.Базарсүрэн, ус хангамж, ариутгах татуургын инженер Б.Сосорбарам, цахилгааны инженер Д.Оюунцэцэг, ерөнхий инженер Ж.Сайнжаргал, барилгын инженер Б.Мөнх, талбайн даамал О.Лхамсүрэн, ХАБЭА ажилтан Г.Одончимэг гэж санал болгосон байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Цахилгааны инженер - 1” гэж шаардсан байх ба “Темплланд” ХХК-аас цахилгааны инженерээр Д.Оюунцэцэгийг санал болгосон тул туслан гүйцэтгэгч “Гексаэдрклауд” ХХК-ийн цахилгааны инженерийн мэдээлэл ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгахад “Темплланд” ХХК тендерт санал болгосон дээрх инженер техникийн ажилчдын мэдээллийг цахим системд үүсгэсэн маягтын дагуу буюу регистрийн дугаар, овог нэр, албан тушаал, холбогдох лавлагаа (диплом, нийгмийн даатгал)-г ирүүлсэн, тус мэдээлэлд үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д шаардлага хангах эсэхийг хянан үзэх боломжтой байх тул “Темплланд” ХХК инженер техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй байна.

5. Гомдолд дурдсан ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар гомдлын хүрээнд хянан үзэхгүй тул энэ талаар холбогдох хууль, хяналтын байгууллагад хандах нь зүйтэй байна.

6. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” Сүүлийн 3 /2021, 2022, 2023/ жилд төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн доод тал нь нэг гэрээний мэдээлэл ирүүлнэ. /Нийт гэрээний нийлбэр дүнгээр тооцно.” гэж, ТШЗ 19.2.3-т “Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 4, 5 дугаар маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл, Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, Улсын комисс хүлээж авсан актын хуулбар, Захиалагчийн тодорхойлолтыг хавсаргаж ирүүлнэ. /Нийт гэрээний нийлбэр дүнгээр тооцно.” гэж заасан байна.

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэлд “Темплланд” ХХК нь Нийслэлийн засаг даргын Тамгын газартай 2018 онд байгуулсан 03/01 дугаартай “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний мэдээлэл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн BA/031/2022 тоот

дүгнэлт, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/1369 тоот тодорхойлолт тус тус ирүүлсэн байна.

Дээрх 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн БА-031/2022 дугаартай барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд 4 дүгээр хавсралтын хамт хүчинтэй гэж дурдсан байх ба “Темплланд” ХХК нь тендерт уг хавсралтыг ирүүлээгүй нь дээрх шаардлагад нийцэх эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/1194 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Энхтөгс тэмүүлэл” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ





“ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД”

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45
Утас: 70049919, 70049973
www.miат.com

2024. 06. 07 № 01/Λ512

таний _____ -ны _____ №-т

Хугацаа сунгах тухай

“МИАТ” ТӨХК-иас зарласан МИАТ/20240101096 дугаартай “Хөшгийн хөндий дэх ангарын барилгын ажил /Оффис цехийн Б хэсэг/” гүйцэтгэх тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр нээсэн.

Уг тендертэй холбоотой Сангийн яамнаас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 03/4164 тоот бичгээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай, 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03/4507 тоот бичгээр гомдол хянасан тухай албан бичиг тус тус ирүүлсэн.

Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 15 хоногоор сунгаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.МОНХТАМИР

